



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/733 дугаар захирамж зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах чиглэлээр хийх төсөл арга хэмжээний саналыг боловсруулах судалгааны ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---------|---------------------------|
| Ахлагч: | Ц.Цолмон /Хэлтсийн дарга/ |
| Гишүүд: | Б.Болор /мэргэжилтэн/ |
| | Г.Бат-оюун /мэргэжилтэн/ |
| | С.Март /мэргэжилтэн/ |
| | Э.Батцэцэг /мэргэжилтэн/ |

2. Судалгааны ажлын үр дүнг 2016 оны 11 дүгээр сарын 16-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг /Ц.Цолмон/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ДЭЛГЭРЭХ